

## УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БОДЛОГО 6: 235-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ДҮРЭМ, ЖУРАМ

### ЦАХИМ СҮЛЖЭЭНД ХОЛБОГДОХ

#### I. Дүрэм, журмын хамрах хүрээ, сүргүүлийн дүүргийн удирдлага

Энэхүү журам, дүрмийг [Удирдах Зөвлөлийн 6:235 бодлогод](#) заасан *Цахим сүлжээнд нэвтрэх* бодлого ("Бодлого")-ийн дагуу хэрэгжүүлэх болно. Эдгээр дүрэм, журам нь Дүүргийн бүх цахилгаан цахим сүлжээ, түүний дотор Дүүргийн эзэмшлийн компьютер, хөдөлгөөнт, үүрэн төхөөрөмж, интернет, түүнчлэн дүүргийн болон дотоод сүлжээг хамарсан (бүхэлд нь "Сүлжээ") хэрэглээг зохицуулдаг. "Хөдөлгөөнт үүрэн төхөөрөмж" гэдэг нь утсан холболтгүйгээр болон бусад хэрэгслээр интернетэд холбогдох боломжтой аливаа цахим төхөөрөмж юм. Дүүргийн сүлжээний интернетэд нэвтрэхийн тулд хувийн хөдөлгөөнт төхөөрөмжийг ашиглах нь тухайн хүн Дүүргийн төхөөрөмжийг ашиглаж байгаатай ижил дүрмийг дагаж мөрдөнө.

Бодлого, дүрэм, журам зохицуулалт нь дүүргийн ажилтнуудын Бодлого эсвэл эдгээр дүрэм, журамд заасны дагуу хэрэгжих бөгөөд нэмэлт дүрэм, журам, сүлжээ ашиглах бусад нөхцөлийг хавсралт болгон оруулах боломжтой.

Удирдах зөвлөлийн зорилго нь боловсролын чанарыг сайжруулах үүднээс мэдээллийг хуваалцах, шинэчлэл хийх, харилцаа холбоог дэмжих замаар дүүргийн сургалтын хөтөлбөрт тохиромжтой Сүлжээний хандалтыг оруулах явдал юм. Сүлжээг ашиглах нь Дүүргийн бодлогын бүх шаардлагад нийцсэн байх ёстой.

#### II. Сүлжээ ашиглах зөвшөөрөл авах

##### A. Эрх бүхий хэрэглэгчид

Сүлжээний эрх бүхий хэрэглэгчид нь Сүлжээнд нэвтрэх эрх олгогдсон, холбогдох зөвшөөрлийн маягтыг бөглөсөн, Сүлжээний давуу эрх нь түдгэлзээгүй эсвэл хүчингүй болоогүй сурагч, багш, удирдлагын ажилтнууд, Дүүргийн бусад ажилтнууд, Боловсролын Удирдах зөвлөлийн гишүүд орно.

##### B. Сурагчид

1. **Дүүргийн эзэмшлийн төхөөрөмжөөр дамжуулан сүлжээнд нэвтрэх.** Дүүргийн- эзэмшлийн компьютер эсвэл Дүүргийн- эзэмшлийн хөдөлгөөнт үүрэн төхөөрөмжөөр дамжин сүлжээнд нэвтрэхийн тулд сурагчид Сурагч болон Эцэг Эх Цахим Сүлжээнд Нэвтрэх маягт дээр гарын үсгийг албан ёсоор зурсан байдлаар (Үзүүлэн 1, "Сүлжээний маягт") бөглөж Дүүргийн хариуцсан ажилтанд өгнө.
2. **Хувийн Хөдөлгөөнт Үүрэн Төхөөрөмжөөр дамжин сүлжээнд нэвтрэх.** Дүүрэг нь сурагчдын сургалтын явцад технологийн хэрэглээ нь үнэ цэнэтэй болохыг хүлээн зөвшөөрдөг. Зарим үед сурагчид хувийн Хөдөлгөөнт үүрэн төхөөрөмжийг сургуульд ашиглаж сурахад тустай байж болох юм. Хувийн Хөдөлгөөнт Төхөөрөмжийг эцэг эхийн зөвшөөрөл, Бодлого ба эдгээр дүрэм, журам зохицуулалтыг сурагч ойлгосны үндсэн дээр багшийн зөвшөөрлийн

дагуу сургалтын зорилгоор Сүлжээг ашиглаж болно. Ийм тохиолдолд сурагч Дүүргийн утасгүй сүлжээг зочин хэлбэрээр ашиглаж, хувийн сүлжээгээ хаах ёстой. Ингэснээр сурагч Дүүргийн бодлого, дүрэм, журам зохицуулалтад нийцсэн шүүлтүүртэй интернетэд нэвтрэх боломжтой болно. Нэмж хэлэхэд, сурагч зөвхөн хувийн Хөдөлгөөнт төхөөрөмж дээр сургалтын програмуудыг ашиглах болно.

Сургуулийн цагаар болон/эсвэл Дүүргийн эзэмшлийн газар сурагчид өөрсдийн дүүргийн болон хувийн хөдөлгөөнт төхөөрөмжийг дараах тохиолдолд ашиглахыг хориглоно: (1) хувийн сүлжээнд нэвтрэх, дүүргийн зочны утасгүй сүлжээг дамжуулж хэрэглэх; (2) багшийн урьдчилсан зөвшөөрөлгүйгээр бусадтай, түүний дотор оюутан, эцэг эх / асран хамгаалагч, найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ утсаар ярих, мессеж бичих, и-мэйл илгээх, эсвэл бусадтай цахим хэлбэрээр харилцах, харин хичээлийн бус цагаар дүүргийн эзэмшлийн газар хувийн төхөөрөмжөөр ийм үйлдэл хийхийг зөвшөөрнө; 3) багшийн урьдчилсан зөвшөөрөлгүйгээр аудио, болон видео бичлэг бичих эсвэл хэн нэгэн сурагч, ажилтны зургийг авах; (4) аливаа зөвшөөрөлгүйгээр олон нийтэд мэдээ тараах; (5) хувцас солих өрөө, угаалгын өрөөнд; (6) Бодлого, эдгээр дүрэм, журамд заасны дагуу хүлээн зөвшөөрөөгүй зүйлийг ашиглах; (7) Удирдах Зөвлөлийн аливаа бодлого, дүрэм, ёс зүйн дүрмийг зөрчсөн аливаа хэлбэр.

Сурагч өөрөө Хөдөлгөөнт Төхөөрөмжийн вирусын эсрэг хамгаалалттай байж, Сүлжээнд нөлөөлж болзошгүй вирус эсвэл бусад файлуудаас ангид байлгахын тулд өөрийн хувийн хөдөлгөөнт төхөөрөмжөө тохируулах, хадгалах үүрэгтэй. Дүүрэг нь хувийн хөдөлгөөнт төхөөрөмж ашигладаг сурагчдад техникийн дэмжлэг үзүүлэх үүрэгтэй биш юм.

Сурагчид өөрийн хөдөлгөөнт төхөөрөмжийн аюулгүй байдал, хамгаалалтыг өөрсдөө хариуцдаг. Дүүрэг нь сурагчдын хувийн гар утасны аюулгүй байдал, хамгаалалт, алдагдах, гэмтэх зэрэгт хариуцлага хүлээхгүй.

Дүүрэг хэрэв Хөдөлгөөнт төхөөрөмж нь сургуулийн бодлого, дүрэм, хууль тогтоомжийг зөрчсөн гэх тодорхой үндэслэлтэй бол сургуулийн эзэмшлийн газар хувийн хөдөлгөөнт төхөөрөмжийн мэдээллийг шалгаж, хайлт хийх болно. Сурагч хувийн хөдөлгөөнт төхөөрөмж ашиглахтай холбоотой дүрмийг зөрчсөн тохиолдолд сахилгын арга хэмжээнээс хөөх хүртэл хэрэгт холбогдуулж болзошгүй.

Хувийн эзэмшлийн хөдөлгөөнт төхөөрөмжөөр дамжуулан Сүлжээнд нэвтрэхийн тулд сурагч Сүлжээний зөвшөөрөл мөн Сурагч болон Эцэг Эхийн Зөвшөөрөлтэй хувийн хөдөлгөөнт төхөөрөмж ашиглах маягтын хамт Дүүргийн томилогдсон ажилтанд ирүүлэх ёстой.

**1.Зөвшөөрлийн маягтын хэрэгжилт, гүйцэтгэл.** Эдгээр маягтыг бөглөсөн сурагчдын бүртгэлийг сурагчдын мэдээллийн санд хадгалах болно. Эдгээр маягтын хуулбар эсвэл цахим мэдээлэл нь сурагчдын хамрагддаг сургуульд хадгалагдана.

Сурагч болон эцэг эх / асран хамгаалагч Сүлжээний зөвшөөрлийн маягт, (онлайн хэлбэрээр эсвэл цаасан дээр) хувийн Хөдөлгөөнт Төхөөрөмжид Зөвшөөрөл олгох маягтыг жил бүрийн хичээлийн жилийн эхэнд бөглөж, илгээх ёстой. Шинээр гарын үсэг зурсан маягтуудыг бөглөсний дараа Дүүрэг сурагчдын

Сүлжээнд нэвтрэх эрхийг сэргээнэ.

Сурагчын Сүлжээний эрх эдлэх давуу талыг түдгэлзүүлэх болон хүчингүй болгоогүй тохиолдолд Сүлжээний Зөвшөөрлийн маягт болон Хувийн Хөдөлгөөнт Төхөөрөмжийн Зөвшөөрлийн маягт нь сурагчын тухайн жилийн эрхийг олгоно. Хэрэв сурагчын Сүлжээний давуу эрх түдгэлзсэн эсвэл хүчингүй болсон бол Сүлжээний Зөвшөөрлийн маягтын шинээр гарын үсэг зурсан хуулбар, Хувийн Хөдөлгөөнт Төхөөрөмжийн Зөвшөөрлийн маягтыг боломжтой бол сурагчын нэвтрэх эрхийг сэргээхийн өмнө ирүүлэх ёстой.

**2. Сахилгын үр дагавар.** Бодлого, дүрэм, журам зохицуулалт эсвэл нэмэлт дүрэм, Сүлжээний бусад нөхцөл, болзлыг зөрчсөн аливаа үйлдэл нь Захирагч болон сургууль хариуцсан захирал нар Сүлжээний давуу эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сахилгын арга хэмжээ авахад хүргэж болзошгүй юм. Удирдах Зөвлөлийн 7:190-д заасны дагуу зохих хууль ёсны арга хэмжээ авна.

### **C. Сурагч-бус хэрэглэгчид**

Дүүргийн эзэмшлийн компьютер эсвэл ямар нэгэн хөдөлгөөнт төхөөрөмжөөр дамжуулан Сүлжээнд нэвтрэхийн тулд багш нар, дүүргийн бусад ажилтнууд, сайн дурын ажилтнууд, Удирдах Зөвлөлийн гишүүд ("Сурагч бус хэрэглэгчид") сурагч-бус Цахим Хандалтын маягтын зөвшөөрлийн гарын үсэг бүхий хуулбарыг ирүүлэх ёстой. (Хавсралт 3, "Сурагч-бус хэрэглэгчийн зөвшөөрөл").

Сурагч-бус хэрэглэгч хичээлийн жил бүрийн эхэнд сурагч-бус зөвшөөрлийн маягтыг бөглөнө. Шинээр гарын үсэг зурсан маягтыг бөглөсний дараа Дүүрэг Сурагч-бус хэрэглэгчдийн сүлжээнд нэвтрэх эрхийг сэргээнэ. Хэрэв Сурагч-бус хэрэглэгчийн сүлжээний эрхийг хаасан эсвэл хүчингүй болгосон тохиолдолд хэрэглэгч нэвтрэх эрхээ сэргээхээс өмнө шинээр гарын үсэг зурсан Сурагч-бус зөвшөөрлийн маягтыг өгөх ёстой.

Бодлого, дүрэм, журам, эсвэл нэмэлт дүрэм, Сүлжээний бусад нөхцөл, болзлыг зөрчсөн аливаа үйлдэл нь Захирагч болон сургууль хариуцсан захирал нар Сүлжээний давуу эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сахилгын арга хэмжээ авахад хүргэж болзошгүй ба зохих хууль ёсны арга хэмжээг авна.

## **III. Сүлжээг ашиглах**

### **D. Хүлээн зөвшөөрөгдсөн хэрэглээ**

**1. Сургалтын хөтөлбөрийн зорилгоор.** Сүлжээнд нэвтрэх нь Дүүргийн сургалтын үндсэн зорилгод нийцсэн үнэн зөв боловсрол, судалгааны зорилгоор хязгаарлагддаг. Хандалт нь мөн Захирагч, Зааварчилгааны Албаны Гүйцэтгэх Захирал, эсвэл Сургуулийн захирлуудын зарласан зарчмаар Бодлого, дүрэм, журам, бусад холбогдох дүрэм Сүлжээнд холбогдох бусад нөхцлүүдийг дагаж мөрдөх ёстой ба Дүүргийн аюулгүй байдал, сурган хүмүүжүүлэх

асуудалд шаардлагатай сахилгын болоод зохицуулалтын арга хэмжээг авна.

**2. Ажилчдын нийтлэг хэрэглээ.** Ажилтан ямар нэг зааварчилгааг сурагчдад өгөөгүй, хяналт тавиагүй эсвэл өөрийн ажил үүрэгтэй холбоотой (жишээ нь, эцэг эхийн хурал, анги доторхи үйлчилгээнүүд, Тусгайлсан боловсролын хөтөлбөр-IEP уулзалт гэх мэт) үүрэг хариуцлага хүлээж байх явцад ажилтнууд хувийн хэрэгцээнд Сүлжээнд нэвтрэх боломжтой. Гагцхүү, энэ нь ажилтны ажил үүргийн гүйцэтгэлд сөргөөр нөлөөлөхгүй, Дүүргийн үйл ажиллагаанд саад учруулахгүй болон бусдын эрх чөлөөг зөрчөөгүй байх ёстой. Энэ хувийн хэрэглээ нь шаардлагатай, мэргэжлийн хандлагатай, байнга зүй зүй зохистой байх ёстой. Дүүргийн ажилчид нь дүүргийг төлөөлж байдаг бөгөөд Сүлжээг ашиглах явцад мэргэжлийн дагуу ажиллах үүрэгтэй.

### **В. Зөвшөөрөхгүй хэрэглээ**

Үүнд хамаарах аливаа зүйл: (1) Дүүргийн сургуулийн зохих, дэг журамтай, сахилга батыг зөрчсөн; (2) Сүлжээний хил хязгаар болон үр ашигтай ажиллагаанд заналхийлсэн; (3) бусдын эрхийг зөрчсөн; (4) олон нийтийн дунд зохисгүй болон сурагчын нас, төлөвшилд тохиромжгүй; (5) хөрөнгө яаралтай хүсэх зорилгоор ашиглах; (6) хууль бус эсвэл аливаа төрлийн хууль бус зорилгоор; (7) Удирдах Зөвлөлийн аливаа бодлого, дүрэм, журмыг зөрчсөн; (8) дуулгаваргүй байдал, зохисгүй үйлдэл нь хүлээн зөвшөөрөгдөхгүй хэрэглээ юм. Сүлжээг аливаа зөвшөөрөгдөөгүй хэрэглээнд ашигласан тохиолдолд Сүлжээний давуу эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, сахилгын арга хэмжээ авах, сургуулиас хөөх (сурагчдын хувьд), ажлаас халах (ажилчдын хувьд), / эсвэл зохих хууль ёсны арга хэмжээ авахад хүргэж болзошгүй юм.

Сүлжээг ашиглахад зөвшөөрөгдөөгүй хэрэглээнд дараахь зүйлийг багтаасан ба үүгээр хязгаарлагдахгүй.

1. Хэрэглэгч аливаа аюул заналхийлэл, түүний дотор кибер дайралт зэргээс үл хамааран аливаа хүн, хэсэг бүлэг хүмүүс, барилга байгууламж, эд хөрөнгөд заналхийлж, эсвэл заналхийлэх гэж ойлгож болох аливаа арга хэмжээ авах. (Кибер дайралт гэдэг нь зохисгүй, хор хөнөөлтэй и-мэйл, шуурхай зурвас, текст мессеж, дижитал зураг, видео эсвэл вэбээр илгээх, нийгмийн сүлжээ, бусад цахим хэрэгслээр дамжуулан сайтад байрлуулах, нийтлэх замаар бусдыг доромжлох, өдөх, айлган сүрдүүлэх, заналхийлэх гэх мэтээр хязгаарлагдахгүй);
2. Бусдын хувийн нууцлал, аюулгүй байдалд халдах, үүнд зөвшөөрөлгүй задруулах, бусад хүний хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй ашигласан гэх мэт хувийн хэрэглээний хаяг, утасны дугаар, гэрэл зураг, видео гэх мэт;
3. Хууль бус, хор хөнөөлтэйгээр ашиглах, доромжлох, ёс суртахуунгүй, луйвараар (боловсролын залилан гэх мэт), гутаах, гүтгэх, бүтээлийн хулгай, хууран мэхлэлт болон зохиогчийн эрх эсвэл оюуны өмчийн эрхийг зөрчих, Холбооны хуулийг зөрчсөн аливаа материалыг дамжуулах зэрэг хэлбэрээр аливаа материалд нэвтрэх, ашиглах, эзэмших
4. Сүлжээг арилжааны, хувийн болон хувийн санхүүгийн ашиг олох зорилгоор мөн түүнчлэн мөрийтэй тоглоом тоглох;

5. Порнограф, бүдүүлэг, зохисгүй үг хэллэг, текст, дуу чимээ, дүрс агуулсан аливаа материалыг битүүмжлэх, санаатайгаар нэвтрэх, үүсгэх, илгээх, нийтлэх, зарлах, дамжуулах, тараах, хүлээн авах, харуулах, өөр аргаар бусдад түгээх;
6. "Спам" эсвэл бусад хүсээгүй мессеж үүсгэх, дамжуулах;
7. Бусад сурагчдын файлууд, багшийн файлууд, нууц мэдээлэл, сурагчдын мэдээллийн сан болон зөвшөөрөлгүй компьютерийн сүлжээний данснууд зэрэг мэдээллийн зөвшөөрөлгүй хандалт хийх;
8. Өөр хүнээс ("spoofing" буюу "хууран мэхлэх" гэж нэрлэдэг) имэйл ирсэн мөн бусад харилцаа холбоог бий болгосон гэх, эсвэл онлайн мэдээлэл дээрээс хуурамч эсвэл төөрөгдүүлсэн мэдээлэл олж авч төөрөлдөх бусад хувь хүн, бизнес, байгууллагатай харилцах
9. Сүлжээ буюу бусад Гар утасны төхөөрөмж, компьютер, компьютерийн системд хадгалагдаж дансны аюулгүй байдлыг алдагдуулах, аливаа тагнуулын эсрэг, антивирус, хэрэглэгчийн баталгаажуулалт, агуулгын шүүлтүүр эсвэл бусад аюулгүй байдлын хэрэгслийг хакердах, өөрчлөх, идэвхгүй болгох, эвдэх, эсхүл тэднийг хууран мэхлэх зэрэг
10. Хэрэглэгчийн зөвшөөрөл эсвэл зөвшөөрөлгүйгээр өөр хэрэглэгчийн Сүлжээний данс буюу нууц үгийг ашиглаж, нэвтрэх
11. Сүлжээний нууц үгийг (түүний дотор өөрийн нууцыг) бусад хүмүүст ил болгох;
12. Сүлжээнд текст файл, дуут, дүрст, зурагт эсвэл бусад файлыг татаж авах, суулгах зэргийг Захирал, Зааварчилгааны Албаны Гүйцэтгэх Захирал, эсвэл Сургуулийн захирал болон бусад холбогдох ажилтнуудаас урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр суулгах;
13. Сүлжээнд програм хангамж татаж авах, суулгах, шинэчлэх ажлыг Захирагч, Зааварчилгааны Албаны Гүйцэтгэх Захирал, эсвэл Сургуулийн захирал болон бусад холбогдох ажилтнуудын урьдчилан зөвшөөрөлгүйгээр хийх. (Програм хангамж суулгахыг хүсч буй ажилтнууд зохих маягтыг өөрсдийн Технологийн зөвлөлд ирүүлэх шаардлагатай.);
14. Сүлжээнд хамааралтай ямар ч компьютер, гар утасны бусад төхөөрөмжид хадгалагдаж байгаа аливаа компьютерийн файлуудыг өөрчлөх, устгах, гэмтээх зорилгоор тагнуул хийх, хортой програм, вирусыг үүсгэх, санаатайгаар татаж авах, байршуулах, дамжуулах;
15. Сургуульд хамааралгүй захидлын жагсаалт, мэдээний бүлгүүд, чат үйлчилгээ, цахим мэдээллийн самбар эсвэл сургуульд хамааралгүй холбоо, үйлчилгээнд Сүлжээгээр дамжуулан бүртгүүлэх, хамрагдах;
16. Сүлжээний менежерийн зөвшөөрлөөс авснаас бусад тохиолдолд Сүлжээнд үүсгэгдсэн, илгээсэн, хүлээн авсан эсвэл хадгалсан аливаа файлыг шифрлэх, кодлох, нууц үгээр хамгаалах;
17. Сүлжээг бусад хэрэглэгчид болон бусад хүмүүсийг доромжлох зорилгоор ашиглах;
18. Сурагч-бус хэрэглэгчдийн хувьд Сүлжээг ашиглан Төрийн албан тушаалтан, ажилтны ёс зүйн тухай хуулийн дагуу "улс төрийн хориотой үйл ажиллагаа", Сонгуулийн тухай хуулийн дагуу "сонгуульд хөндлөнгөөс оролцох", эсхүл Дүүргийн ажилчдын улс төрийн үйл ажиллагаатай холбогдсон эдгээр хуулиуд эсвэл дүүргийн ёс зүйн бодлогын дагуу зохисгүй байдлыг төрүүлж буй аливаа улс төрийн үйл ажиллагаанд оролцох.

19. Файлын зай эсвэл принтерийн нөөц гэх мэт Сүлжээний нөөцийг үрэлгэн байдлаар ашиглах;
20. Дүүргийн Сүлжээ буюу боловсролын үйл явцад саад учруулах, хөндлөнгөөс оролцох, түүний дотор бусдын эрхэнд халдах, алдагдалд хүргэх боломжтой гэж үзсэн хэрэглээ;
21. Удирдах зөвлөлийн 6: 235-ийн зорилгод нийцээгүй Сүлжээний ямар ч хэрэглээ.
22. Ажилчдын хувьд Удирдах Зөвлөлийн 5:125, Цахим харилцаа холбоо, нийгмийн сүлжээ, түүнийг хэрэгжүүлэх удирдамж / журмыг дагаж мөрдөхгүй байх;
23. Ажилчдын хувьд Сүлжээний хувийн хэрэглээ нь ажилчдын ажил, үүрэгт сөргөөр нөлөөлдөг, дүүргийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлдөг, эсвэл бусдын эрхийг зөрчих;
24. Ажилтнуудын хувьд хувийн (өөрөөр хэлбэл, дүүргийн бус) и-мэйл данс, интернет данс, мессеж бичих, хувийн цахим харилцааны бусад хэрэгслээр дамжуулан Удирдлагын болон түүний томилсон хүний урьдчилсан зөвшөөрөлгүйгээр нийгмийн сүлжээнд нэвтрэх, бусад ажилтнуудтай харилцах, нийгмийн харилцаанд орох
25. Сурагчдын хувьд Сүлжээг Удирдах Зөвлөлийн Сахилгын бодлого болон сурагчын ёс зүйн дүрмийн аливаа заалтыг зөрчсөн хэлбэрээр ашиглах;
26. Амжилттай хэрэгжсэн тохиолдолд хүлээн зөвшөөрөгдөөгүй хэрэглээ болох аливаа үйлдэл хийхийг оролдох.

#### **IV. Сурагчид дотоод Сүлжээ болон Интернетийн хэрэглээ**

##### **A. Журам**

Сурагчид Сүлжээг ашиглахдаа багш нар болон энэхүү Бодлого, дүрэм, журмыг дагаж мөрдөнө.

Сурагчид сургууль дээрээ байхдаа интернэтэд нэвтрэх нь зөвхөн багшийн шууд удирдлага дор сургалтын зорилгоор эсвэл Удирдах Зөвлөлийн бодлогод заасны дагуу эсвэл Дүүргийн хүүхэд бүрт ологодсон iPad санаачлагын дагуу зөвшөөрөгдсөн байна.

##### **B. Интернетийн аюулгүй байдал**

Тус Дүүргийн интернетийн холболтын чухал асуудал бол сурагчдын аюулгүй байдал, хамгаалалтыг хэзээ ч алдагдуулахгүй байх явдал юм. Зарим аюулгүй ажиллагааны хамгийн үр дүнтэй арга хэмжээг зөвхөн сурагчид өөрсдөө хэрэгжүүлэх боломжтой. Дүүрэг эцэг эх/асран хамгаалагчдад хүүхдүүдтэйгээ дараах аюулгүй байдлын талаар ярилцахыг зөвлөж байна:

1. Сурагчид хэзээ ч хувийн мэдээлэл болох нэр, нас, гэрийн хаяг, утасны дугаар(ууд), гэрэл зураг, эцэг эх / асран хамгаалагчийн ажлын хаяг, утасны дугаар, сургуулийн нэр, байршил зэргийг интернетээр болон и-мэйлээр дамжуулан тарааж болохгүй. Сурагчид хэзээ ч бусад хүний тухай хувийн мэдээллийг Интернетээр эсвэл имэйлээр дамжуулж болохгүй.
2. Сурагчид интернет, имэйлээр эсвэл бусад цахим харилцаа холбоогоор

дамжуулан ямар нэгэн мэдээлэл, эвгүй байдалд хүргэх мэдээлэл авсан бол эцэг эх, асран хамгаалагч, дүүргийн ажилтнуудад нэн даруй мэдэгдэх ёстой. Сурагчид ийм төрлийн и-мэйл эсвэл бусад мессежэд хариу өгөх ёсгүй.

3. Сурагчид эцэг эхэд мэдэгдэлгүйгээр тэдний зөвшөөрөл, хяналтгүйгээр онлайнаар “танилцсан” хүнтэй уулзахаар хэзээ ч зөвшөөрөх ёсгүй.
4. Сурагчид эцэг эхэд мэдэгдэлгүйгээр тэдний зөвшөөрөл, хяналтгүйгээр онлайнаар “танилцсан” хүнд аливаа зүйлийг илгээх, хүлээн авахыг хэзээ ч зөвшөөрөх ёсгүй.

## **V . Материал Татаж Суулгах**

Хэрэглэгч нь Сүлжээн доторх цахим сүлжээ, электрон шуудан, бичмэл мэдээллийн багц дамжуулах протокол, болон файл түгээх бусад аргуудаар олж авсан файлууд, зурагнууд, болон бусад файлууд эсхүл програм хангамжийг зөвхөн Захирагч, Зааварчилгааны Албаны Гүйцэтгэх Захирал, эсвэл Сургуулийн захирал болон бусад холбогдох ажилтнуудын зөвшөөрлөөр компьютерт татаж суулгаж болно. Хэрэглэгч нь Дүүргийн компьютерт тэдгээр файлуудыг суулгах, үйлдэл гүйцэтгүүлэх, хуулахдаа вируснаас хамгаалах програм хангамжаар шүүллэх ёстой.

## **VI. Нүүц байдал**

Сүлжээгээр дамжуулан үүсгэсэн, хадгалагдсан, илгээсэн, хүлээн авсан ямар ч цахим харилцаа, файл нь Дүүргийн компьютероор ч байсан, хувийнхаар ч байсан, мөн ямар ч Хөдөлгөөнт төхөөрөмжийн хэрэгсэл байсан Дүүргийн хяналт, шалгалтын дагуу байна. Тийм учраас хэрэглэгч нь тэдгээр зурвас, файлууд нууцлаг байна гэдэг хандлага гаргахгүй. Хэрэглэгч нар тэдгээр мессеж, файлууд нь өөрийнх нь хувийн бүртгэлтэй хэрэглүүрт нь устгагдсан байсан ч Цахим сүлжээний хадгаламжийн системд эргэн сөхөгдөнө гэдгийг санах. Электрон шуудан бичихдээ бичгээр үйлдэж буй баримт болон албан бичиг үйлдэхтэй ижил хэмжээний анхаарлыг хүн бүр тавих хэрэгтэй. Э-шууданд албан бичиг юмуу захианд зохимжгүй ямар ч зүйл цацагдах ёсгүй.

Дүүргийн Захирал, Зааварчилгааны Албаны Гүйцэтгэх Захирал, эсвэл Сургуулийн захирал болон бусад холбогдох ажилтан нар шаардлагатай үед Сүлжээний үр дүнтэй ажиллагаа болон ёс зүйг хамгаалахын тулд; Дүрмийн мөрдөлт хэрэгжилтийг болон эдгээрийн журам, зохицуулалтуудыг хянах, Дүүргийн Захирал түүний томилсон ажилтан нарын гаргасан Сүлжээнд нэвтрэх заалтууд ба нөхцөлүүд, мөн бусад бүх мөрдлөгүүд; боловсролын болон аюулгүй байдал, багшлах арга зүйн асуудлуудыг цаашид сайн явуулахын тулд харилцах зурвасуудад болон файлуудад нэвтэрч хянаж болно. Дүүрэг нь хэрэглэгчид мэдэгдэх болон мэдэгдэхгүй аль ч хэлбэрээр Сүлжээн дотор ямар ч цаг үед хийгдсэн, илгээсэн, хүлээн авсан, хадгалсан мэдээлэлд хориг тавих, нэвтэрч орох, 3-дагч хуулийн этгээдэд хуваалцах эрхийг эдэлнэ.

Сүлжээг ашиглан ямар нэгэн электрон хандалт хийх болон файл бичих, хадгалах, илгээх, хүлээж авах, харах, нэвтрэх нь хэрэглэгч хүн Дүүрэгт эдгээр файлд нэвтрэх, хяналт тавих зөвшөөрлийг энэ догол мөрөнд дурдсаны дагуу олгосон гэж үзнэ.

Ямар ч хэрэглэгчид Дүүргээс олгосон е-мэйл хаяг нь Дүүргийн өмч ба, Дүүрэг нь Дүүргийн хууль ёсны зорилгоор сурагч биш хүнд олгосон е-мэйл хаяг бүхий бүртгэлийг 3дагч хуулийн этгээдэд хуваалцах эрхийг эдэлнэ.

Дүүрэг нь боловсролын агуулга бүхий суулгацууд/арр/, цахим хуудаснууд хувийн эрхийн стандартын шаардлагатай нийцэж буй эсэхийг хянах бүх оролдлогыг хийдэг. Хэдий тийм ч Дүүрэг боловсролын агуулгатай суулгац болон цахим хуудасны борлуулагч нар нь зөвшөөрөлгүйгээр сурагчдын мэдээллийг авсан тохиолдолд хариуцлага хүлээхгүй.

## **VII. Технологи Хамгаалах Үйл ажиллагаа**

Сүлжээн холбоогоор холбогдсон Дүүргийн компьютер, Зөөврийн Электрон Хэрэгсэл бүрт Дүүргийн бодит боловсролын болон багшлах арга зүйн асуудалтай уялдаатайгаар Дүүрэг нь програм хангамжийг хянан шүүх болон хаалт хийх хүртэл технологи хамгаалах шийдэл хэрэгжүүлнэ. Хүүхдийг цахим орчинд Хамгаалах хуульд тодорхойлсоноор хүүхдийн компьютерийн хэрэглээ нь тэдэнд хохирол үзүүлэх эсвэл зохимжгүй байвал гэсний ижлээр ийм технологи хамгаалах шийдэл нь хэрэглэж болохуйц хамгийн сайн арга барилаар аливаа нэг материалд нэвтрэхээс хамгаалах, үүнд; жигшмээр, үзэгдэхүйц дүрслэлүүд, порн орсон, хүүхэд уруу татан оруулсан порн зэрэг орно. Дүүргийн Захирал, Зааварчилгааны Албаны Гүйцэтгэх Захирал, эсвэл Сургуулийн захирал, бусад томилогдсон ажилтнууд сурагчдын бус, насанд хүрэгчдийн тусгайлсан компьютер дээр үнэнхүү судалгааны ажлын материал хайх болон өөр хуулийн дагуух эрхээр нэвтрэх тохиолдолд технологи хамгаалах шийдэлийг цуцалж болно.

Захирал, Зааварчилгааны Албаны Гүйцэтгэх Захирал, эсвэл Сургуулийн захирлуудын зарласан зарчмаар Бодлого, дүрэм, журам, бусад холбогдох дүрэм Сүлжээнд холбогдох бусад нөхцлүүдийг дагаж мөрдөх ёстой ба Дүүргийн аюулгүй байдал, сурган хүмүүжүүлэх асуудалд шаардлагатай сахилгын болоод зохицуулалтын арга хэмжээг авна.

## **VIII. Аюулгүй байдал**

Сүлжээний халдашгүй байдал болон ёс зүй нь бидний гол анхаарч буй зүйл юм. Хэрэглэгчид өөрийн бүртгэлтэй хаяг, нууц үгийг байнга найдвартай, нууц байлгана. Хэрэв Сурагч болон Сурагч-бус Сүлжээний халдашгүй байдал алдагдсан, ажиллагаа муу байх, зарчмын зөрчил гарсан нь анзаарагдсан тохиолдолд Дүүргийн ажилтанд даруй мэдэгдэх ёстой.

Хэрэглэгч ийм төрлийн алдагдал, ажилагааны чанар болон зөрчлийг ашиглахгүй байж, энэ талын мэдээллийг бусад хувь хүмүүст тараахгүй байх. Энэ үйл явцыг зөрчсөн ямар ч хэрэглэгч нь Сүлжээ хэрэглэх эрхээ түр болон бүр цуцлуулах, сахилга батын арга хэмжээ авах хүртэл, мөн бусад тохирох хуулийн хариуцлага хүлээх болно.

## **IX. Баталгаа гаргахгүй**

- А.** Дүүрэг Сүлжээгээр холбогдсон үед алдагдсан аливаа мэдээлэл, үзүүлэлтүүд, Сүлжээн дээр олж авсан үйлчилгээ болон мэдээллийн чанарын асуудал, үнэн зөв эсэх байдалд хэрэглэгч нартаа санал болгох юмуу аман байдлаар болон бусдаар Сүлжээгээр хангах үйлчилгээндээ ямар ч баталгаа гаргахгүй. Дүүрэг хэрэглэгчдэд учирсан аливаа хохирол, үүнд: гацсанаас үүдсэн алдагдсан мэдээлэл үзүүлэлт, огт гарч ирэхгүй байдал, хоцорч ирсэн байдал, үйлчилгээний доголдолд хариуцлага хүлээхгүй. Сүлжээнээс авсан аливаа мэдээллийн хэрэглээнд Хэрэглэгч өөрөө эрсдэлийг тооцно.
- В.** Дүүрэг Сүлжээгээр олж авсан мэдээллийн үнэн зөв байдал, чанарын асуудалд ялангуяа хариуцлага хүлээхгүй. Дүүрэг зөвшөөрөл өгөөгүй аливаа мөнгөн төлбөрт хариуцлага хүлээхгүй, үүнд утсаар ярьсан төлбөр, холын дуудлагын

төлбөр, минутаар тооцогддог нэмэлт төлбөрүүд, мөн/ эсхүл хэрэгслэл болон шугамын үйлчилгээний үнэ, хувь хүний Сүлжээг хэрэглэхтэй холбогдсон түүнээс үүдэлтэй, үр дагавартай төлбөрүүд орно.

- С.** Дүүрэг хүүхдүүдийн компьютерийн хэрэглээг анхааралдаа авч жигшүүртэй, порно агуулгатай, муу нөлөө үзүүлэх, хүүхдэд зохисгүй материалд нэвтрэхээс хамгаалж програм хангамжийн шүүлт, хаалт, бусад технологос хамгаалах арга барилыг сонгож нэвтрүүлэхдээ шудрага журам, зохистой аргаар хандаж байдаг. Гэсэн хэдий ч Сүлжээг хэрэглэх явцад эдгээр технологос хамгаалах шийдэл нь бүх хориотой материалд нэвтрэх байдлаас хамгаалж чадахгүй гэдгийг, мөн хориотой бус материалд нэвтрэхэд саад учирна гэдгийг хүлээн зөвшөөрөх. Дүүрэг технологос хамгаалах зорилгоор хэрэгжүүлж буй шийдлийн дагуу нэвтрэх хориг тавьсан ба нэвтэрч орсон асуудлуудад хариуцлага хүлээхгүй.

## **X. Нөхөн төлбөр олгох**

Хэрэглэгч нь Сүлжээний холбогдолтой эсхүл хэрэглэгчийн Сүлжээг хэрэглэж байх явцад гарсан, эсхүл Дүүргийн Захирагчийн болон түүний томилсон ажилтнуудын зарласан зарчмаар Бодлого, дүрэм, журам, бусад холбогдох дүрэм Сүлжээнд холбогдох бусад нөхцөлүүдийг зөрчсөнөөс болж Дүүрэгт учруулсан аливаа хохирол, өртөг, гэмтэл, төлбөр ба торгууль үүнд; утасны төлбөр, холын дуудлагны төлбөр, минутаар тооцогддог нэмэлт төлбөрүүд, хэрэгслэл болон шугамын үйлчилгээний төлбөр, эсхүл өмгөөлөгчийн төлбөрийг ба үүгээр хязгаарлагдахгүйгээр Дүүрэгт нөхөн төлнө.

## **XI. Мөрдөн шалгалттай хамтран ажиллах**

Дүүрэг нь хууль сахиулах байгууллагын алба болон Сүлжээг хэрэглэж байх явцад хохирсон гэж мэдүүлэгч талын гаргасан эсвэл хүссэн аль ч мөрдөн шалгах ажиллагаанд оролцох ба бүрэн төгс хамтран ажиллах эрхийг эдэлнэ. Хууль бус үйл ажиллагааны баримтыг холбогдох ажилтнуудад өгч мэдээлнэ.

## **XII. Хэрэгжүүлэлт**

Дүүргийн Захирал эсвэл Сургуулийн захирлуудын зарласан зарчмаар Бодлого, дүрэм, журам, бусад холбогдох дүрэм Сүлжээнд холбогдох бусад нөхцөлүүдийг дагаж мөрдөхийг зөрчсөн хэрэглэгч Сүлжээний хэрэглэгчийн давуу эрхээ түр цуцлуулах болон бүр хаалгахад хүрэх, сахилга батын арга хэмжээ авах, болон хуулийн хариуцлага хүлээнэ.

Сахилга батын арга хэмжээг Дүүргийн сахилга батын арга хэмжээ авах мөрдлөгтэй уялдаатайгаар өгнө. Сахилга батын арга хэмжээнд Сурагч-Бус хэрэглэгч бол үүргээс нь чөлөөлнө, Сурагч хэрэглэгчийг бол сургуулиас хөөнө.

## **XIII. Журамд өөрчлөлт оруулах тухайд**

Удирдах Зөвлөл болон түүний томилсон ажилтнууд энэхүү Бодлого, дүрэм, журам, бусад холбогдох дүрэмд өөрчлөлт оруулж болно. Сүлжээний болон Дүүргийн сургууль тус бүрийн аюулгүй, зүй ёсны, үр нөлөө бүхий ажиллагааг бататгахад хэрэг болох Сүлжээнд нэвтрэх нэмэлт дүрэм, зохицуулалтууд, эсхүл бусад заалт юмуу нөхцөлүүдийг Дүүргийн Захирагч юмуу Сургуулийн Захирлууд заах болно. Ийм өөрчлөлтүүд юмуу нэмэлт дүрэм, зохицуулалтууд, эсхүл нэвтрэх талаарх бусад заалт нөхцөлүүдийн мэдэгдэл нь цаг тухай бүрт бүх зөвшөөрөлтэй хэрэглэгчдэд дамжуулж

тухайн өөрчлөлтийг Сүлжээн дээр байршуулж Дүүргийн байрнуудад харагдахуйц байдлаар тавина. Сүлжээг хэрэглэх явц нь Дүүргийн Захирагч, Сургуулийн Захирал, тэдгээрийн томилсон ажилтнуудын заасны дагуу энэхүү Бодлого, дүрэм, журам, бусад нэмэлт дүрэм, зохицуулалтууд, Сүлжээнд нэвтрэх заалт, нөхцөлүүдийг хүлээн зөвшөөрсний үндсэнд явагдана.

### Хавсралт 1

#### Сурагч ба Эцэг эхийн Сүлжээнд нэвтрэх Зөвшөөрөл.

*\*Сурагч уншиж зөвшөөрсөн байх ёстой*

Энэхүү Бодлого, дүрэм, журам, бусад холбогдох Зохицуулалтуудад хавсаргасны дагуу Дүүргийн Сүлжээний хэрэглээний тухай би уншсан, эсвэл надад тайлбарлаж өгсөн ба би Дүүргийн Сүлжээг хэрэглэхдээ эдгээр мөрдлөгүүдийг дагаж мөрдөнө гэдгээ зөвшөөрч байна. Би Дүүргийн Сүлжээний мөрдлөгийг зөрчвөл сахилга батын шийтгэл хүлээнэ. Эдгээр шийтгэлд Сүлжээг хэрэглэх эрхээ хаалгах, байцаагдах, түр чөлөөлөгдөх, хөөгдөх болон бусад үр дагавартай хариуцлагыг хүлээнэ. Дүүргийн Сүлжээг ашиглан хийсэн, байршуулсан мөн нэвтрэн орсон ямар ч мэдээлэл, баримт бичиг нь Дүүргийн эзэмшил ба Дүүргийн ажилтан болон бусад хүмүүст нээлттэй харагдахуйц байх ба баримт бичгүүд нь ямарч байдлаар нууцлаг болохгүй юм. Энэ систем дээр байршуулсан мэдээлэл болон баримт бичиг устах болон гэмтэлд орох боломжтой гэдгийг ойлгож байна. Хэрэв би цахилгаан сүлжээг буруугаар ашиглаж Сүлжээнд болон хэн нэгэнд, эсвэл хэн нэгний мэдээлэл, баримт бичигт гэмтэл учруулбал, би сахилгын хариуцлага хүлээх ба би болон миний эцэг эх/ асран хамгаалагч гэмтэл, буруу хэрэглээний төлбөрийг бүрэн хариуцна. Доор гарын үсэг зарсанаар Хавсаргасан Бодлого, дүрэм, журмыг ойлгож зөвшөөрснөө би батлан харуулж байна.

***\*Сурагчид эцэг эх/ асран хамгаалагч нартаа дараахийг уншуулж зөвшөөрүүлсэн байх ёстой:***

Би Дүүргийн Сүлжээнд Нэвтрэх Бодлого, түүний хэрэгжүүлж буй Дүрэм, журмыг уншсан ба хүлээн зөвшөөрч байна. Хандалт нь боловсролын зориулалттай хийгдсэн бөгөөд Дүүрэг, олон нийтийн маргаантай материалыг хасахын тулд урьдчилсан арга хэмжээ авсан гэдгийг би ойлгож байгаа.

Хэдий тийм боловч Дүүрэг нь бүх олон нийтийн маргаантай болон зохисгүй мэдээлэлд нэвтрэхийг хязгаарлах боломжгүй гэдгийг би бас ойлгож байна. Миний хүүхэд сөрөг мэдээлэлрүү интернетээр нэвтэрч магадгүй гэдгийг би ойлгож байгаа. Би Дүүрэг, холбогдох ажилтнууд, төлөөлөгч, эсвэл Удирдах Зөвлөлийн албаныхныг Сүлжээгээр дамжин олж авсан програм хангамж болон материалаас учирсан хохиролд тохохгүй. Миний хүүхдийн хэрэглээ нь сургуулиас гадуур тохиолдолд байхад би хяналт анхаарлын бүрэн хариуцлагыг хүлээнэ.

Дүүргийн цахим сүлжээний аливаа зохисгүй хэрэглээ нь миний хүүхдийн компьютерийн сүлжээний эрхийг цуцлах, түр хаах ба миний хүүхдэд сахилга батын арга хэмжээ авахуулах, сургуулиас хөөх хүртэлх болон үүнээс гадна эрүүгийн болон иргэний хэргийн торгуульд хүргэж болзошгүй гэдгийг би ойлгож байна.

Миний хүүхдийн Дүүргийн цахим сүлжээний хэрэглээтэй холбоотой болон, эсхүл Дүүргийн Бодлого, дүрэм, журам, зохицуулалтуудыг зөрчсөнөөс үүдсэн, учруулсан аливаа хохирол, үнэ, гэмтэл, төлбөр, торгуульд би хариуцлага хүлээх ба Дүүрэгт нөхөн төлөөс хийнэ гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Миний хүүхэд Дүүргийн компьютер сүлжээний хэрэглээнээс Дүүргийн аль нэг бодлого, дүрэм, журмыг зөрчсөн эсвэл зөрчсөнтэй холбоотой миний хүүхдэд болон надад учирсан хохиролд Боловсролын Хяналтын Алба, түүний Удирдах Зөвлөлийн гишүүн нэг бүр, ажилтан, төлөөлөгчид, томилогдсон ажилтнуудыг буруутгаж тэдэнд тохохгүй гэдгийг хүлээн зөвшөөрч миний хүүхдэд компьютерийн сүлжээнд нэвтрэхийг эрхийг Дүүргээс хангаж өгөхийг хүсч байна.

Би Сүлжээний Зөвшөөрлийн Гэрээний нөхцөлүүд, холбогдох Дүүргийн бодлого, арга хэмжээнүүдийг өөрийн хүүхэдтэйгээ зөвлөлдсөн.

Иймд би, миний хүүхдэд Дүүргийн Сүлжээний нэвтрэлтийг хангаж өгөхийг хүсч байна.

---

Эцэг эх/Асран хамгаалагчийн нэр (*үсгээр бичнэ үү*)

---

Эцэг эх/Асран хамгаалагчийн гарын үсэг

---

Огноо

---

Сурагчийн нэр (*үсгээр бичнэ үү*)

---

Сурагчийн гарын үсэг

---

Огноо

## Хавсралт 2

### Багш болон Сурагч-бус бие бүрэлдэхүүний цахим сүлжээнд нэвтрэх хандалт болон хэрэглээ

Удирдах Зөвлөлөөс гаргасан дүүргийн сургуулийн компьютер Сүлжээг хэрэглэх дүрэм журам, зохицуулалт, чиг хандлагыг тогтоосон хугацаа, нөхцөл байдлын дагуу мөрдөж биелүүлэхээ хүлээн зөвшөөрснөө дор гарын үсэг зурснаар баталж байна.

Зохисгүй хэрэглээ гаргасан тохиолдолд сүлжээнд нэвтрэх эрх нь түр хаагдах эсвэл хасуулах болон нэмэлт сахилга батын арга хэмжээ авах, эрхээс нь түдгэлзүүлэх цаашилбал иргэний болон гэмт хэргийн хариуцлага хүлээнэ гэдгийг ойлгож байна.

Дүүрэг Сүлжээний хэрэглээний талаар илэрхийлсэн бүх түдгэлзүүлэх зөвшөөрөл ба ямар нэгэн шуурхай зөвшөөрөл байхгүйг, Сүлжээ хэрэглэх үед олж авсан мэдээллүүд алдагдах, мэдээллийн нарийн байдал ба чанар зэрэг дээр хариуцлага хүлээхгүй болохыг ойлгосон болно.

Дүүргийн компьютер болон Хөдөлгөөнт төхөөрөмжөөс илгээсэн, хадгалсан, хүлээж авсан, үйлдсэн бүх цахилгаан файлууд нь Дүүргийн өмч болохыг эдгээр мэдээллүүдэд хүссэн цагтаа нэвтрэх эрх байхгүйг, нэврэх эрх нь Дүүрэгт байгаа бөгөөд Баримт 6 дээр заасан Бодлого, дүрэм журам, зохицуулалтын дагуу явагдахыг хүлээн зөвшөөрч байна.

Нэмж дурдахад, Дүүргийн интернет Сүлжээг хэрэглэхдээ Захирагч болон Сургуулийн Захирлын гаргасан Бодлого, дүрэм журам, бусад зохицуулалтыг сахиагүйгээс болон Дүүргээс гаргасан интернет хэрэглээний дүрэм журам, зохицуулалтын дагуу тогтоогдсон хугацаа нөхцөл байдалын дагуу хэрэглээгүйгээс болж гаргасан бүх хохирол, зардал, алдагдал, Хөдөлгөөнт төхөөрөмжийн хэрэглээний үйлчилгээний хураамж, олон улсын үүрэн телефоны үйлчилгээний хураамж, тоног төхөөрөмжийн үнэ, хуульчийн хөлс зэргийг нөхөн төлж хохирлыг барагдуулах ёстогоо хүлээн зөвшөөрч, Glenview 34-р дүүргийн сургуулиудын Боловсролын Удирдах зөвлөл, ажилтан, төлөөлөгч, гишүүнд дүүргийн интернэт сүлжээг хариуцлагагүй хэрэглээнээс үүссэн бүх хохирлыг нөхөн барагдуулахаа мэдэгдэж байна.

Нэр: \_\_\_\_\_

Гарын үсэг: \_\_\_\_\_

Албан тушаал: \_\_\_\_\_ Он сар өдөр: \_\_\_\_\_

**Хавсралт 3 – Хувь хэрэг тус бүрд хэрэглэгдэх хэрэглээ**  
**Хувийн хөдөлгөөнт төхөөрөмжийн хэрэглээний**  
**зөвшөөрөл**

***\*Сурагч уншаад зөвшөөрсөн байх ёстой.***

Би Дүүргийн интернет хэрэглээ ба хувийн хөдөлгөөнт төхөөрөмж хэрхэн хэрэглэх Бодлого, дүрэм журам, зохицуулалтыг тайлбарлуулж уншсан болно.

Би хувийн Хөдөлгөөнт төхөөрөмжийн хэрэглээний мөрдөх ёстой дараах дүрмүүдийг дагах болно.

Би хувийн Хөдөлгөөнт төхөөрөмжийн хэрэглээний дүрмийг зөрчсөн тохиолдолд сахилгажуулалт хүлээн авна гэдгээ ойлгосон болно.

Тус сахилгажуулалт нь хувийн Хөдөлгөөнт төхөөрөмж хэрэглэх эрхээ хасуулах, хорио тавигдах, түдгэлзүүлэх, хөөгдөх болон бусад үр дагаварууд орсон болно.

Хувийн Хөдөлгөөнт төхөөрөмж дээр хийгдсэн, илгээсэн, хүлээж авсан бүх мэдээлэл, албан бичиг эсвэл харилцаа холбооны мэдээллүүд нь хувийн хаалттай бус хэрэгцээтэй үед Дүүргийн ажилтан болон бусад ажилтанууд үзэж болохыг ойлгосон болно.

Мөн би хувийн Хөдөлгөөнт төхөөрөмжийн техникийн үйлчилгээ, аюулгүй байдал, баталгаат байдал зэрэг бүх тал бүрэн хариуцлага үүрэхээ ойлгосон болно.

Доор гарын үсэг зурснаар, Би Хавсаргасан эдгээр Бодлого, дүрэм журам, зохицуулалтыг дагаж мөрдөхөө нотолж байна.

***\*Сурагч дараахыг эцэг эхдээ уншуулан гарын үсэг авах шаардлагатай:***

Сургууль дээрээ хувийн Хөдөлгөөнт төхөөрөмжийн хэрэглээний талаар Дүүргээс гаргасан Сүлжээ хэрэглээний дүрэм журамыг хүлээн зөвшөөрч, эдгээр Бодлого, дүрэм журам, зохицуулалтыг хэрэгжүүлэх талаар хүүхэдтэйгээ ярилцан уншиж судалсан болно.

Манай хүүхэд Дүүргээс зөвшөөрөгдсөн аюулгүй Сүлжээг хэрэглэх бөгөөд хувийн сүлжээг хэрэглэх ёсгүйг ойлгосон болно.

Хувийн Хөдөлгөөнт төхөөрөмжийг зохисгүй хэрэглэсэн тохиолдолд Хөдөлгөөнт төхөөрөмж хэрэглэх эрхээ хураалгах, хорио авах болон Хөдөлгөөнт төхөөрөмж хэрэглэх хэрэглээний эрх нь үгүй болох цаашилбал сахилгажуулалт ба иргэний болон гэмт хэргийн хариуцлагыг хүлээн авах ба сургуулиас хөөгдөх хүртэл арга хэмжээ авагдахыг ойлгосон болно.

Түүнчлэн манай хүүхэд Хөдөлгөөнт төхөөрөмжийн техник үйлчилгээ, аюулгүй байдал, баталгаат байдал зэрэг бүх тал дээр хариуцлага үүрэх болохыг ойлгосон болно.

Дүүргээс гаргасан Бодлого, дүрэм журам, зохицуулалт ба зөвшөөрөлийг би хүүхэдтэй ярьж хэлэлцсэн болно.

Манай хүүхэд хувийн Хөдөлгөөнт төхөөрөмж хэрэглэх зөвшөөрлийг би олгож байна.

Эцэг эх/Асран хамгаалагчийн нэр (үсгээр бичнэ үү)

\_\_\_\_\_

Эцэг эх/Асран хамгаалагчийн гарын үсэг

\_\_\_\_\_

Огноо

\_\_\_\_\_

Сурагчийн нэр (үсгээр бичнэ үү)

\_\_\_\_\_

Сурагчийн гарын үсэг

\_\_\_\_\_

Огноо

## **Хавсралт 4 - Олон нийтийн сүлжээнд өөрийгөө болон хүүхдүүдээ аюулгүй байлгах нь**

### **Сурагчдын хувьд:**

- Бүх зүйлээ нууц үгээр хамгаалагдсан хананы ард байрлуул, зөвхөн найзууд чинь харах боломжтой.
- Нууц үгээ хамгаалаарай, найзынхаа жагсаалтад хэн нэгнийг оруулахаас өмнө хэн болохыг сайн мэдэж байгаарай.
- Өөрийн зургаа бага зэрэг бүдэгрүүлсэнээр цахим доромжлол болон хүүхэд мөлжигч нарт ашиглагдахгүй.
- Эцэг эх, сургуулийн захирал болон хүүхэд мөлжигч нар харж чадахгүй ямар ч зүйлийг бүү нийтэл.
- Чиний оруулсан нийтлэл онлайнаар - үүрд !!!! хадгалагдана. Тиймээс ThinkB4UClick! Товч дарахаас өмнө бод!
- Интернетэд холбогдоогүй байхдаа юу ч хэлдэггүйтэй адил холбогдсон үедээ ч юу ч битгий хий, юу ч битгий хэл.
- Өөрийн болон найз нөхдийнхөө нууцлалыг хамгаалаарай. Тэдэнтэй холбоотой зураг, мэдээллийг нийтлэхээсээ өмнө асууж байгаарай.
- Найзууд тань чиний талаар юу бичиж, юу ярьж байгааг шалгана уу. Хэдийгээр чи маш болгоомжтой байсан ч найзууд тань чамайг эрсдэлтэй байдал оруулж болзошгүй юм.
- Тэр хөөрхөн 14 настай хүү үнэндээ хөөрхөн биш, 14-тэй ч биш, эрэгтэй хүүхэд ч биш байж болох юм! Чи хэзээ ч мэдэхгүй!
- Та өөрийн блогоо коллеж/ажилд орох/дадлага хийх/тэтгэлэг хүсэх эсвэл спортын багдаа зориулж хавсаргахаас бусад тохиолдолд олон нийтэд нийтэлж болохгүй!
- Зогс, Блокло, Хэл! (ямар ч цахим доромжлол, дээрэлхэлт агуулсан мессэжд хариу үйлдэл үзүүлэхгүй байх. Тэр хүнийг блоклож, итгэдэг насанд хүрсэн хүнд хэлээрэй).
- Х-Ү-Н-Д-Э-Л! (сүлжээг ёс зүйтэй ашиглаж, бусдын мэдрэмж, мэдээлэл дамжуулалтын хурдыг хүндэтгэх).
- Хувийн мэдээллээ нууцлах (хэн нэгэн таны талаар илүү их мэдээлэлтэй байх тусам тэд таныг дээрэлхэж болзошгүй).
- Өөрийгөө Google-д! (онлайнаар хувийн мэдээллээ тогтмол хайж, Цахим халдлага байгаа тохиолдолд эрт мэдэх үүднээс өөртөө сануулга өг).
- 5-ыг аваарай! (чиний компьютер/хөдөлгөөнт төхөөрөмжид ямар нэгэн таагүй зүйл ирэхэд чи хожим нь ямар нэг харамсах зүйл хийхгүйн тулд 5 минутын турш түүнээс холдож яв).

### **Эцэг эхийн хувьд:**

- Хүүхдүүдтэйгээ ярилц - асуулт асуу (дараа нь тэд чамд үнэн ярьж байгаа эсэхийг баталгаажуулах хэрэгтэй!)
- Маргааш тэдний профайл хуудсыг харахыг хүсээрэй! (Энэ нь тэдэнд тохиромжгүй ба аюултай гэх зүйлээ бүгдийг нь устгах боломжийг олгодог. Энэ нь тэдэнд юу нийтлэхгүй байхыг зааж өгөх болно!)
- Айх хэрэггүй ... хүүхдүүдээ онлайнаар аюулгүй байлгах аргууд байгаа. Таны бодож байгаагаас амархан!
- Оролцоотой байж, бусадтай хамтран ажилла.
- Ихэнх хүүхдүүд нийгмийн сүлжээг зөвхөн найзуудтайгаа харилцахдаа ашигладаг. Амьсгалаа аваад, бодлоо цэгцлээд, хэрэгтэй үед тусламж аваарай. Хэрэв гадны хүмүүс үүнийг үзэх боломжтой бол тэдний хувийн нууцад халдсан зүйл биш юм. Оймсныхоо

шүүгээнд шургуулсан тэмдэглэлийн дэвтэртээ бичсэн тэмдэглэлийг унших, сүлжээнд нийтэлсэн блог унших 2-т ялгаа байдаг шүү. Нэг нь цаасан дээр бичигдсэн; нөгөө нь цахим ертөнцөд амьдардаг 700 сая хүн үзэх!

- Уншсан бүх зүйлдээ битгий итгээрэй - ялангуяа өсвөр насныхны блог дээрээ нийтэлсэн зүйлд!